

МОНГОЛ ДАХЬ ХЯТАД СУДЛАЛЫН БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Г.Цогзолмаа
МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн захирал
доктор (PhD), дэд профессор

Товч агуулга:

- Хятад хэлний сургалтын талаар түүхэн тойм
- Оюутан, судлаач сургаж буй тухай
- Мэргэжилтэн багш, сайн дурын багш нар урьж ажиллуулж ирсэн тухай
- Мэргэжилтэн бэлтгэх шинэ загвар
- Судалгааны арга зүйн хичээл орж буй туршлагаас
- Уран зохиолын бүтээл орчуулгын тойм

Түлхүүр үг: *Хятад судлалын мэргэжилтэн, түүхэн замнал, өнөөгийн байдал, боловсон хүчин, ирээдүй*

Хятад хэлний сургалтын талаар түүхэн тойм:

Монгол Улс, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоож 71 дэх жилдээ хамтран үйл ажиллагаа явуулж байна.

Түүхэн баримтаас үзвэл Монгол Улсад хятад хэлийг албан ёсоор 1957 оноос МУИС-д анх зааж эхэлсэн байдаг бөгөөд өдгөө 2017 онд түүхт 60 жилийн ой тохиожээ. Энэ хугацаанд манай улсад хятад хэлний олон мянган мэргэжилтэн төрөн гарчээ.

Энэ жил Монгол Улсад хятад хэлний мэргэжилтэн бэлдээд 63 жилийн нүүртэй золгож байна.

Монгол Улсад хятад судлаач, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж эхэлсэн түүхийг бид гурван үед хуваан үздэг.

I Эхлэлийн үе- /1957-1968 он/

II Сэргэлтийн үе- /1973-1990 он/

III Хөгжлийн үе- /1990 оноос одоог хүртэл/

Эдгээр түүхэн үеийн дотроос 1990-ээд оноос хойш хоёр улсын харилцаанд онцгой өөрчлөлт гарч хятад хэлний мэргэжилтэн бэлтгэх асуудлаар олон ахиц гарсныг бид мэднэ. Энэ талаар 2009 онд Дэлхийн хятад хэл заах аргын холбооны

сэтгүүлд “Монгол Улсын хятад хэлний сургалтын өнөөгийн байдал” сэдэвт өгүүлэлдээ сургалтын тойм, сурах бичиг, багшлах боловсон хүчний талаар хийсэн судалгаагаа тоймлон үзүүлсэн.

Хятад хэлний сургалт явуулж эхэлсэн түүх (1957- өнөөг хүртэл)

Сургуулийн нэр	Сургуулийн өмчлөлийн хэлбэр	Хятад хэлний мэргэжил нээсэн огноо	Хятад хэлний багш мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн огноо	Хятад хэлний багш бэлтгэсэн хугацаа	Хятад хэлний багш мэргэжлийн үйл ажиллагаагаа соёсон огноо	Хятад хэлний багшаар бэлтгэсэн хүний тоо
МУИС	Улсын	1957	1990	16	2005	272
МУБИС	Улсын	1993	1993	19	Үргэлжлүүлэн хятад хэлний багш бэлтгэж байгаа	266
Дорнод их сургууль	Улсын	2003	2003	4	2005	40
Хүмүүнлэгийн ухааны сургууль	Хувийн хэвшлийн	1990				40
Отгонтэнгэр их сургууль	Хувийн хэвшлийн	1991	1991	15	2008	
Түгээмэл их сургууль	Хувийн хэвшлийн	2001			2011	
Монгол үндэсний их сургууль	Хувийн хэвшлийн	2002	2002	3	2005	-

Хятад хэлний мэргэжилтэн бэлтгэж байсан тухай өөрчлөлт шинэчлэлийн түүх

	Их дээд сургууль	Суралцах хугацаа	Өөрчлөлтийн өмнөх мэргэжил	Өөрчлөлтийн дараах мэргэжил
1	МУИС	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэл судлал
2	МУБИС	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэлний багш

3	Дорнод их сургууль	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэлний орчуулагч
4	Хүмүүнлэгийн ухааны сургууль	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэлний орчуулагч
5	Отгонтэнгэр их сургууль	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэлний орчуулагч
6	Түгээмэл их сургууль	4 жил	Хятад хэлний багш орчуулагч	Хятад хэлний орчуулагч

Шинэ үеийн хятад судлал ХХ зууны дунд үеэс үүдэлтэй 1949 онд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосноор цаашид хоёр орны харилцааг холбох гүүр болсон хятад судлаачдыг цөөн тоогоор хятадын их дээд сургуульд сургаснаас Ч.Далай, доктор Чой.Лувсанжав, “Монголын нууц товчоо” судлаач Л.Маналжав нарын нэрт эрдэмтэд, хятад судлаачид төрөн гарсан юм.

Л.Маналжав доктортой 20 гаруй жил судалгаа, шинжилгээний ажлаа харилцан ярилцаж байгаа бөгөөд 2016 онд МУБИС-ийн 65 жилийн түүхт ойн номыг бичих хариуцлагатай ажилд тохоон томилогдож, бичих явцдаа архив, номын сангийн арвин сан хөмрөгөөс чухал материал олсноо хятад судлаачийн хувьд үнэлж баршгүй санагдаж “Боловсролын түүчээ” түүхийн номын 345 дугаарт шигтгээ болгон бүрэн эхээр нь оруулсан билээ. /Боловсролын түүчээ/

Хятад хэл бичиг сурч байна

Багшийн институтийн тоо физикийн факультетын 3 дугаар курсийн онц суралгат оюутан, Чойбалсангийн цалинт Лувсанжав, 1951 оноос эхлэн бие дааж хятад хэл бичиг сурч эхэлжээ.

Хятад хэл мэддэг хүмүүсийн туслалцаа, толь бичиг зэргийг хэрэглэж хялбар жижиг зүйлийг орчуулан унших зэргээр цөхрөлтгүй оролдсоны дүнд одоо хөнгөн хялбар үгтэй хятад ном сониныг уншдаг болоод цаашид улам шаргуу суралцаж байна.

Л.ХУУШААН

Үнэн сонин, 1952 оны 10 дугаар сарын 24, баасан, №253 (5237)

/Үнэн сонины архивын материалаас/

Хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш 1957 оноос эхлэн анхны мэргэжилтэн бэлтгэж ирсэн тухай баримтад өгүүлсэн байдаг бол бүр 1952 оны “Үнэн” сонинд 1951 оноос манай нэрт эрдэмтэн Чой.Лувсанжав хятад хэл сурч эхэлсэн тухай “Хятад хэл сурч байна” мэдээнд өгүүлсэн буй. Өөрөөр хэлбэл, дипломат харилцаа тогтоосноос хойш 3 жилийн дараа хятад хэл сурч байсан

баримт бидэнд олдсоноор бидний судалгаанд нэг шинэ содон ул мөрийг үлдээж өгсөн байх юм.

Оюутан судлаач сургаж буй тухай

Хоёр орны харилцаанд гарсан өөрчлөлтийн үр дүнд Монгол Улсын иргэд БНХАУ-ын тэтгэлгээр олноороо суралцах болсон. 1990-ээд оноос эхлэн энэ тоо тасралтгүй өссөн билээ. Бид зарим нэг тоо баримтыг авч үзье.

2007-2016 онд Засгийн газрын тэтгэлгээр суралцсан оюутны тоо

Огноо	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Дүн
БНХАУ-д очиж суралцсан монгол оюутны тоо	2715	3618	4774	5684	6211	7112	8210	7920	7428	8508	54752
Монгол Улсад ирж суралцсан оюутны тоо	302	406	374	331	314	-	449	-	-	-	2146
Дүн											

Эх сурвалж: www.csc.edu.cn

Тэтгэлгийн ангилал:

БНХАУ-д бүх төрлийн тэтгэлэг авч буй монгол оюутны судалгаа

Төрөл	ЗГ-ын тэтгэлэг	Муж, хотын тэтгэлэг	Сургуулийн тэтгэлэг	Бусад тэтгэлэг
Доктор	12.1%	33.5%	57.6%	6.8%
Магистр	10.8%	34.6%	37.1%	17.5%
Бакалавр	10.1%	36.7%	38.3%	15.9%
Дүн				

Эх сурвалж: www.csc.edu.cn

Нийт тоо	111		114		128	
Хүйс	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хүйс	10	101	11	103	8	120
Хүйсийн харьцаа	9%	91%	9.6%	90.4%	6.3%	93.7%

Эх сурвалж: www.csc.edu.cn

1990-ээд оноос БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр маш олон тооны оюутан суралцаж байгааг зөвхөн 2007-2016 оны хооронд авсан тоо баримтаас харж болно. Тэгэхээр зөвхөн 10 жилийн хугацаанд 54752 оюутан суралцсан гэсэн тоо баримтыг үзвэл 1990-2020 оны хооронд БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэг, бусад муж, хот, сургуулийн тэтгэлгийг бүрнээр тооцон үзвэл түүнээс илүү тооны дүн гарах юм. Эдгээр суралцаж төгссөн, сурч байгаа төгсөгчид ч Монголын хятад судлалын салбарт хувь нэмрээ оруулсаар байгаа бөгөөд цаашид ч тасралтгүй хувь нэмрээ оруулсаар байх болно. Мөн түүнчлэн хятад судлаач, эрдэмтэд БНХАУ-д урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлэх, судалгааны ажилд хамтран оролцох зэргээр судалгаа, шинжилгээний ажлаа тасралтгүй өргөжүүлж байна.

Ахисан шатны сургалтын талаар:

БНХАУ-д магистр, докторын түвшний сургалтад маш олон тооны суралцагчид сурч төгсч байгаа бөгөөд эдгээр төгсөгчид Монгол Улсын хятад судлалд хувь нэмрээ оруулсаар байна.

Хятад, Монголын солилцоонд зориулсан тусгай тэтгэлэгт хөтөлбөрүүд жил бүр нэмж зарлагдаж байна.

2015-2019 онд 5 жилийн хугацаатай тусгай тэтгэлэг зарлагдсан бөгөөд жил бүр 200 хүртэл тооны судлаач оюутныг магистр, докторын ахисан шатны сургалтад сургах гэрээний дагуу сургаж эхэлсэн. Энэ талаар мэдээлсэн байх юм.

Хятад, Монголын солилцоонд зориулсан тусгай тэтгэлэгт хөтөлбөрт БНХАУ-ын Боловсролын яам, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санамж бичиг” -т гарын үсэг зурах ёслол 21-ний өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод болов.

Энэхүү санамж бичиг нь хоёр орны боловсролын салбарт найрсаг хамтын ажиллагаа, солилцоог улам бүр өргөжүүлэн хөгжүүлэх, Монгол Улсад үндэсний бүтээн байгуулалтад шаардагдах гол салбарын мэргэжлийн хүмүүсийг төлөвшүүлэх, БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгийг ашиглан жил бүр Монгол Улсад бакалавр, магистр, доктор оюутнуудаар хангахад оршино. (200 квот, хэрэгжүүлэх хугацаа 5 жил байна.)

БНХАУ-ын Боловсролын яамыг төлөөлж БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ван Сяолун, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Гантөмөр нар энэхүү санамж бичигт гарын үсэг зурав. Ван Сяолун хэлэхдээ энэхүү тэтгэлгийг боловсрол, урлаг, геологи, архитектур, барилгын инженер, уул уурхайн инженер, газрын тос, байгалийн хийн инженер, мал эмнэлэг, мал аж ахуй, газар тариалангийн инженерчлэл зэрэг 10 чиглэлээр авьяас чадварыг хөгжүүлэхэд зарцуулах болно гэжээ. (Сурвалжлагч Ян Тао)

“People’s Daily” (2015 оны 4 дүгээр сарын 22-ны 21 дэх хэвлэл)

Мэргэжлийн чиглэлийн хувьд авч үзвэл сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг 10 мэргэжлээр сургах гэрээ хийсэн. Зөвхөн эхний онд буюу 2015-2016 оны хичээлийн жилд 140 магистр, доктор элссэн. Таван жилийн гэрээний дагуу 1000 оюутан элсэн суралцах гэрээтэй.

Харин энэ хугацаанд элссэн элсэгчдийн төгсөлтийн асуудал бидний анхаарлыг татаж байна. Үүнд зөвхөн эхний жилд докторын шатны сургалтад 70 гаруй хүн суралцсан бол өдгөө төгссөн хүний тоо 2-3-ын тоонд эргэлдэж байгаа нь тун чамлалттай санагдана.

Басхүү магистрын зэрэг авахаар суралцаж байгаа хүмүүсийн 70% орчим хувь төгсч байгаа гэсэн бүрэн бус мэдээ ч бас л чамлалттай.

БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээс гадна ахисан шатны түвшний суралцагчдад зориулсан тэтгэлгүүд сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. Үүнд:

Бид зөвхөн боловсрол судлалын чиглэлээр хийсэн ажлыг толилуульж байна.

**БНХАУ-Д ХАМГААЛСАН МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ТАЛААР ХИЙГДСЭН
ДОКТОРЫН БОЛОН МАГИСТРЫН СУДАЛГААНЫ АЖЛУУД /2006-2015 он/**

№	论文	作者	学位	单位	年度
1.	中国与蒙古高等教育行政管理结构比较研究	金光	博士	东北师范大学	2006
2.	蒙古高等教育结构调整的经济与社会因素分析	恩和扎亚	硕士	山东大学	2015
3.	蒙古、中国高等教育信息化比较研究	Naidanjav Gerelmaa	硕士	华东师范大学	2012
4.	蒙古国高等教育发展研究	德·钢期木格	硕士	哈尔滨师范大学	2012
5.	蒙古国高等教育服务贸易现状与对策	阿莫勒祖拉 (Amarzul Tumor)	硕士	大连海事大学	2013
6.	蒙古国立大学外语系汉语写作课的调查与分析	马婧韬	硕士	黑龙江大学	2014
7.	蒙古国基础教育课程改革现状及问题研究	巴娅日玛 (BATBAYAR BAYARMAA)	硕士	东北师范大学	2010
8.	蒙古、中国基础教育信息化比较研究	Nanzaddorj Erdenetsogt	硕士	华东师范大学	2012
9.	蒙古国中学数学教育史研究 (1921-1990)	宝乐日玛 (D.BOLORMAA)	硕士	内蒙古师范大学	2013
10.	蒙古国全民扫盲教育研究	白吉日木吐	硕士	内蒙古大学	2014

№	论文	作者	学位	单位	年度
11.	蒙古国学前教育发展存在的问题研究	<u>Ganbat Nandin-Erdene</u>	硕士	哈尔滨工业大学	2015
12.	蒙古国远程教育应用现状与发展研究	<u>GERELCHIMEG ARIYA</u>	硕士	华东师范大学	2013
13.	蒙古国社会转型时期义务教育研究	乌妮尔	硕士	东北师范大学	2012
14.	蒙古国传统教育的特征——基于相关蒙语成语的文本分析	恩日乐	硕士	东北师范大学	2012
15.	蒙古、中国基础教育课程改革比较研究	<u>Lkhamsuren Tumenbaatar</u>	硕士	华东师范大学	2007
16.	蒙古国区域经济发展研究	卡娃	博士	吉林大学	2014
17.	蒙古国教育发展史研究	冯福林	硕士	河北大学	2009
18.	中蒙两国学前教育的比较研究	<u>Unenbuyan Luvsmaa</u>	硕士	辽宁大学	2020
19.	一个蒙古学生留学经历自我叙事研究	<u>Batsuren Amarjargal</u>	硕士	浙江师范大学	2020
20.	蒙古国学前教育发展的历史与现状研究	<u>Chuluunbat Mijidmaa</u>	硕士	浙江师范大学	2020
21.	蒙古国师范教育的发展、问题与对策研究	<u>Buyantogtokh Oyuntungalag</u>	硕士	浙江师范大学	2020
22.	蒙古国中小学残疾人教育中存在的问题解决对策研究	<u>Dorjderem Altansukh</u>	博士	哈尔滨师范大学	2020
23.	中蒙教育学硕士研究生课程比较研究	<u>Erdenebileg Bolortuya</u>	博士	哈尔滨师范大学	2020
24.	蒙古国第十五次中学化学课程改革的新思维	<u>Baatarchuluun Solongoo</u>	博士	哈尔滨师范大学	2020
25.	新形势下蒙古国义务教育改革研究	<u>Sedkhuu Tsetsegsuren</u>	硕士	哈尔滨师范大学	2020
26.	蒙古国高等教育发展现状与对策研究	<u>Soyolmaa</u>	硕士	湖南大学	2019
27.	蒙古国留学生学习经历与跨文化适应研究	<u>Bayarsaikhan Oyuntulkuur</u>	硕士	湖南大学	2018

№	论文	作者	学位	单位	年度
28.	蒙古国初中生母语课程学习动力研究	Ganbold Solongo	硕士	湖南大学	2018
29.	蒙古国与中国高等教育中性别差异问题比较研究	Tamir Bayarsaikhan	硕士	山东大学	2017
30.	蒙古国高等院校组织结构研究	Nyamdolgor Khaliun	硕士	山东大学	2017
31.	俄罗斯教育制度对当代蒙古国基础教育制度的影响	Tuvshintungalag.P	硕士		2017
32.	蒙古国留学生话语标记语使用情况研究	Tamir Baatar	硕士	北京外国语大学	2016

Эх сурвалж: <http://www.cnki.net>

Цаашид ахисан түвшний сургалтад суралцаж төгсөгчдийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийх, шаардлага хэрэгцээ буй болж байна. Хэдийгээр тэтгэлэгт хамрагдсан ахисан түвшний суралцагчдын тоо олон байгаа боловч төгсөгчдийн чанарын асуудал, хугацаандаа төгсөж чадаж буй эсэх талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

Монгол Улсад сайн судлаачдыг бэлтгэх зорилгоор хичээлийн хөтөлбөрт судалгааны арга зүй хичээл оруулж буй туршлага:

МУБИС-д сайн судлаачдыг бэлтгэх зорилгоор 2014-2015 оны хичээлийн жилээс бакалаврын хөтөлбөрт “Судалгааны арга зүй хичээл” оруулах болсноос гадна бүх түвшний сургалт ялангуяа ахисан шатны түвшний сургалтад суралцагчдын судалгааны чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор сурах бичгүүд хэвлэн судалгаанд ашиглаж байна. Судалгааны арга зүй хичээлийн байдлыг товчоолон үзүүлбэл:

№	Сургалтын түвшин	Хичээлийн нэр	Судалбал зохих кредит	Сурах бичиг	Тайлбар
1.	бакалаврын түвшин	Судалгааны арга зүй I	2 кр	Судалгааны арга зүй /2017 онд хэвлэсэн/	2014 оноос эхлэн анх удаа бакалаврын түвшинд орж эхэлсэн
2.	магистрын түвшин	Судалгааны арга зүй II	4 кр	Судалгааны арга зүй /2018 онд хэвлэсэн/	

№	Сургалтын түвшин	Хичээлийн нэр	Судалбал зохих кредит	Сурах бичиг	Тайлбар
3.	докторын түвшин	Судалгааны арга зүй III	4 кр	Судалгааны арга зүй /2018 онд хэвлэсэн/	
4.	Дүн		10 кр		

Хятад судлаачдын судалгааны ажлын талаар:

Хятад судлаачдын гаргасан нэлээд олон бүтээлүүд буй боловч энэ удаа сүүлийн жилүүдэд гаргасан гол гол бүтээлийн талаар цухас дурдъя.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс гаргасан Д.Шүрхүү, Б.Энхчимэг нарын 2016 онд хамтран гаргасан “Монголын хятад судлал” аман түүх бүтээлд Монголын хятад судлалын төлөөлөл болсон Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор Л.Маналжав нарын 14 эрдэмтний аман яриаг бүтээлийн жагсаалтын хамт гаргасан.

Мөн “Монгол, Хятадын харилцаа жарнаас жаранд” (2010), “Хятад судлалын салбар Нэгэн жаран” (2017) зэрэг МУИС-аас гаргасан бүтээлүүдэд Монгол Улсад хятад судлаач бэлтгэж ирсэн түүх, 30 гаруй хятад судлаачдын намтар, гол гол судалгааны чиглэл, бүтээлийн жагсаалтыг оруулан өгснөөр хятад судлалын талаар илүү ихийг мэдэх боломж олгож байна.

Мөн түүнтэй зэрэгцүүлж судлаач, доктор Н.Ариунгуа, Ч.Батцэцэг нар “БНХАУ дахь Монгол судлал”, харин судлаач, доктор Н.Алтанцэцэг, Б.Ганчулуун нар “Монгол дахь хятад судлал” өгүүллийг мөн нийтлүүлжээ.

Судлаач, доктор Н.Алтанцэцэг, Б.Ганчулуун нар өгүүлэлдээ 90-ээд оноос хийгдэж буй судалгааны чиглэлийг таван ангилалд хувааж, голлох судлаачдыг бүтээлийн төлөөлөлтэй хамт гаргасан. Үүнд:

Нэг. Улс төр, гадаад бодлого, хоёр орны харилцааны судалгаа (Д.Баярхүү, Ц.Гомбосүрэн, М.Батчимэг, Н.Алтанцэцэг, Х.Олзвой, Ц.Батбаяр, Ч.Далай, Л.Бэгзжав, Ду Шивэй, Ч.Батцэцэг нарын эрдэмтэд, судлаачид, тэдний бүтээлүүд)

Хоёр. Хятадын эдийн засгийн хөгжилт, эдийн засгийн гадаад бодлого, Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны талаарх судалгаа (Д.Батбаяр нарын эрдэмтэд, судлаачид, тэдний бүтээлүүд)

Гурав. Хятадын дотоод бодлого, нийгэм-улс төрийн судалгаа (Ц.Батбаяр, Д.Шүрхүү, Л.Лхамдулам, Д.Түвшин, Н.Алтанцэцэг, Н.Төмөр, Н.Отгонсүрэн, Д.Баярхүү, Ч.Батцэцэг, Н.Ариунгуа нарын эрдэмтэд, судлаачид, тэдний бүтээлүүд)

Дөрөв. Монгол дахь хятад судлалын нэг чухал салбар бол түүх, эх сурвалж судлал (Ж.Баясах, Н.Ариунгуа, Н.Төмөр, Н.Алтанцэцэг, Т.Эрдэнэхишиг, Н.Ишжамц Н.Наран нарын эрдэмтэд, судлаачид, тэдний бүтээлүүд)

Тав. Хэл шинжлэл, утга зохиол, хятадын гүн ухаан, шашин, соёлыг судалж буй талаар (М.Чимэдцэеэ, В.Батмаа, Ц.Бямбацэнд, Д.Бадмаанямбуу, Г.Цогзолмаа, Б.Ганчулуун, Ө.Саранцэцэг, Б.Отгонсүрэн)

Энэ өгүүлэлд ороогүй нэрт судлаач Л.Маналжав “Монголын нууц товчооны хэлний судалгаа” 2017, “Хэл шинжлэлийн өгүүллүүд” 2018 зэрэг хятад судлалын чиглэлийн дорвитой бүтээлүүд гаргаад байна.

Мөн цаашид хятад судлаач эрдэмтдийн талаар нэгдсэн ботиуд бүтээл гаргаж эрдэмтдээ сурталчлах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Өнөөгийн Монгол Улсад хятад судлалын ажлыг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Стратеги судлалын хүрээлэн, МУИС, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Хүмүүнлэгийн Их сургууль зэрэг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд эрхлэн явуулж байгаа талаар 2019 онд хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагууд хийсэн ажлын талаар түүхээ тоймлож гаргасан нь тун сайшаалтай ажил болсон.

2014 онд Хятад, Орос, Монгол 3 орны удирдлага Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс”, “Монголын талын зам”, Оросын “Евро-Азийн хөгжлийн бүс” хэмээх төслүүдийг нэгтгэж, Европ-Азийг дамнасан Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор төсөл зарласан.

Энэ төслийн хүрээнд БНХАУ-ын Хөх хотноо 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд 3 улсын олон улсын хурал хуралдсан. Энэ төслийн хүрээнд бид дараах байдлаар чиглэлээр хамтран ажиллах боломжийг олж харсан. Үүнд:

Хүмүүс хоорондын харилцаа болон шинжлэх ухааны хамтын ажиллагааны маш том орон зай байна. Мөн олон тооны БНХАУ-д төгссөн төгсөгчдийн хүчийг ашиглах нэгтгэх боломж бидэнд олдсон нь бүрэн бус тоон баримтаас харагдаж байгаа юм.

• **Уран зохиолын бүтээл орчуулгын тойм**

Шинжлэх ухаан, хүмүүс хоорондын солилцооны түвшинг дээшлүүлэн хоёр улсын ард түмнүүдийн бие биенээ мэдрэх мэдрэмжийг сайжруулах нь чухал байна. Энэ талаар 2 улсын хооронд хийж байсан ажлын түүхээс эргэн санахад илүүдэхгүй биз ээ. Тухайлбал, 1949 оноос эхлээд 1960-аад он, 80-аад онд Монголын уран зохиолын дээж бичгээс олноор орчуулж ард нийтийн хүртээл болгож байсан.

д/д	Зохиол	Зохиолч	Орчуулагч	Хэвлэх үйлдвэр	Хэвлэсэн огноо
1	Манай сургуулийнхан	Ч.Лодойдамба	Норов, Chen NaiXiong	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1955
2	Аюуш	Д.Сэнгээ	Сэддорж	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1955
3	БНМАУ-ын шүлгийн түүвэр	Д.Нацагдорж нар	MoNan	Шинэ уран зохиолын хэвлэх үйлдвэр	1955

д/д	Зохиол	Зохиолч	Орчуулагч	Хэвлэх үйлдвэр	Хэвлэсэн огноо
4	Дамирангийнхан	Д.Тарва	Chen NaiXiong	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1956
5	Алтайд	Ч.Лодойдамба	Сэддорж	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1956
6	“Булшин дээр”	Д.Цэвэгмид	Номин	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1956
7	Түмний төлөө	Ч.Лодойдамба	KunFu	Хүүхдийн хэвлэлийн үйлдвэр	1956
8	Эрэлхэг танкчин бүсгүй	Д.Нацагдорж нар	KunFu,HaSi	Хүүхдийн хэвлэлийн үйлдвэр	1957
9	Улаан тугийн одон	ChenNaiXiong	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1957
10	“Учиртай гурван толгой” жүжгийн зохиол	Д.Нацагдорж	Номин	Шинэ уран зохиолын хэвлэх үйлдвэр	1957
11	“Үүрийн туяа” I боть	Б.Ренчин	DaJi	Ардын уран зохиолын хэвлэх үйлдвэр	1958
12	“Үүрийн туяа” II боть	Б.Ренчин	WenXi	Ардын уран зохиолын хэвлэх үйлдвэр	1958
13	5 үзэгдэлт жүжиг “Учиртай гурван толгой”	Д.Нацагдорж		БНХАУ-ын жүжгийн хэвлэх үйлдвэр	1959
14	Цэдэнжав шүлгийн түүвэр	Цэдэнжав	CaoDu	Шанхайн уран зохиолын хэвлэх үйлдвэр	1959
15	“Зам” жүжгийн зохиол	Ч.Ойдов	LuQing	БНХАУ-ын жүжгийн хэвлэх үйлдвэр	1960
16	Залуу жуулчид	Надмид	Chen NaiXiong	Өвөр Монголын ардын хэвлэх үйлдвэр	1960
17	Гэрэлт зам	Дашдондов	Chen NaiXiong	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1961
18	“Үүрийн туяа” III боть	Б.Ренчин	DaJi	Ардын уран зохиолын хэвлэх үйлдвэр	1962

д/д	Зохиол	Зохиолч	Орчуулагч	Хэвлэх үйлдвэр	Хэвлэсэн огноо
19	Шүлгийн түүвэр	Д.Сэнгээ	Chen NaiXiong	Зохиолчдын хэвлэх үйлдвэр	1963
20	Цагаан сар ба хар нулимс	Д.Нацагдорж нар	Chen NaiXiong	Өвөр Монголын ардын хэвлэх үйлдвэр	1980
21	Тунгалаг тамир	Ч.Лодойдамба	Wen ZhongHe	Өвөр Монголын ардын хэвлэх үйлдвэр	1984
22	Б.Лхагвасүрэн шүлгийн түүвэр	Б.Лхагвасүрэн	HaSen	Үндэстний хэвлэх үйлдвэр	2008

Монголын уран зохиолын орчуулсан байдлын түүхэн тоймыг товчоолон үзүүлбэл:

Д/д	Он дарааллын хуудас	Орчуулсан зохиолын тоо	Тайлбар
1	1955-1965 онууд	22 орчим	Өгүүлэл, жүжиг, шүлэг, яруу найраг
2	1965-1970 онууд	Бараг байхгүйтэй адил	
3	1970-1980 онууд	10 бүтээл	Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс” 黑种和 1980
4	1980-аад онууд		Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” 1984
5	Одоо үед	Б.Лхагвасүрэнгийн шүлгийн түүвэр	

Мэргэжилтэн бэлтгэх, судалгаа хийлгэх ажлыг зохион байгуулан явуулдаг болсон нь хятад судлалын хойч үеийг өргөн хүрээтэй бэлтгэх боломж олгож байна.

Мөн БНХАУ-д олон оюутан янз бүрийн мэргэжлээр сургаж байгаа нь хятад судлалын ажлыг хойшид эрчимжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байна.

**БНХАУ-ын Засгийн газрын мэргэжилтэн багш нар,
сайн дурын багш нар ажиллуулж ирсэн тухай**

• **БНХАУ-ын Засгийн газрын мэргэжилтэн багш нар ажиллуулж ирсэн тухай:**

МУБИС-ийн хятад хэлний салбарт БНХАУ-ын ӨМБИС-ийн эрдэмтэн багш нарыг урьж ажиллуулж ирсэн бөгөөд 1993-2007 онд нийт 9 мэргэжилтэн багш,

2007 оноос БНХАУ-ын Засгийн газрын мэргэжилтэн багшийг урьж ажиллуулсан бөгөөд 2007-2020 оны хооронд 7 багш, нийт 16 багш ажиллаж хятад хэлний сургалтын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулсан байна.

• **БНХАУ-аас уригдаж ирсэн сайн дурын багш нар ажиллуулж ирсэн тухай**

Мөн хятад хэлний сургалтыг сайжруулах, хөрш орны хамтын ажиллагааны хүрээнд засгийн газрын мэргэжилтэн багш нар, мөн 2005 оноос эхлэн гэрээний дагуу сайн дурын багш нарыг урьж ажиллуулах болсон.

Засгийн газрын мэргэжилтэн багш нарын хувьд тооны хувьд тун цөөн бөгөөд жилдээ 1-3 багш ажиллаж байсан бол гэрээ хийгдсэнээс хойш сайн дурын багш нар тодорхой тоогоор ажиллах болсон.

Сайн дурын багш нарын ажилласан байдлын товчоон /2005-2020 он/

Д/д	Хичээлийн жил	Багшийн тоо	Тайлбар УБ хот/Орон нутаг
1	2005-2006	12	-
2	2006-2007	21	-
3	2007-2008	54	-
4	2008-2009	75	-
5	2009-2010	109	-
6	2010-2011	125	-
7	2011-2012	127	-
8	2012-2013	121	-
9	2013-2014	145	-
10	2014-2015	154	-
11	2015-2016	135	-
12	2016-2017	161	100/29
13	2017-2018	161	85/27
14	2018-2019	157	80/20
15	2019-2020	148	79/17
16	ДҮН	1705	1705

2005-2020 оны хооронд нийт 1700 гаруй сайн дурын багшийг /давхардсан тоогоор/ урьж ажиллуулсан байна. Монгол Улсын бүх шатны боловсролын байгууллагад хятад хэлний багшийн хэрэгцээ ямар их буйг нотолно.

**Монгол Улсад шинэ загвараар өндөр чадвартай
багш мэргэжилтэн бэлтгэж буй туршлага:**

Монгол Улсын бүх шатны боловсролын байгууллагад хятад хэлний багшийн эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэж байгааг дээрх сайн дурын багш нарын тооноос тодорхой харж болно.

Энэ орон зайг нөхөх зорилгоор МУБИС-ийн НХУС-ийн хятад хэлний багшийн ангид 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрийг 2015-2016 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2019,2020 онд эхний төгсөлтүүдээ хийж, нийт 25 оюутан хос дипломтой төгсөөд одоо багшилж байна. Эдгээр оюутнууд төгсөхдөө HSK, HSKK түвшний болзол хангаж, бүх кредитийг судалснаар хос дипломын болзлоо хангаж байгаа юм. Хоёр жил Монгол Улсад, хоёр жил БНХАУ-д суралцах хугацаандаа зөвхөн багш мэргэжил эзэмшээд зогсохгүй хэл соёл, түүхийн мэдлэг, ярианы чадвар, сонсох чадвар нь сайтар хөгжиж буйгаас харж болно.

Уг хөтөлбөрөөр төгсөгчдийн давуу тал нь:

- Хос дипломтой төгсөж байна.
- Хятад хэлний түвшин тогтоох шалгалт өгч, HSK, HSKK шалгалтын үнэмлэх авснаар хэлний түвшин нь бүрэн тодорхойлогдож байна.

Санал

Хятад судлаач бэлтгэх хөтөлбөр болон залуу судлаачдын хувьд цаашид судалгааны чиглэлээр мэргэшихэд дараах хэдэн зүйлийг санал болгож байна. Үүнд:

1. Хятад судлаачдыг бүх талын өвч мэдлэгтэй, өргөн мэдлэгтэй болгож хөгжүүлэхэд хөтөлбөрийн агуулгад онцгой анхаарах
2. Хятад хэлний өндөр мэдлэгтэй судлаачдыг судалгааны нарийн чиглэлээр дагнан мэргэшүүлэхэд онцгой анхаарч, сонгон судлах хичээлийн агуулгад дахин өөрчлөлтүүд хийх
3. Хятад судлаач бэлтгэх сургалтын хөтөлбөрт эртний хятад хэлний агуулга, 繁体字 дэлгэрэнгүй оруулах
4. Дан ганц хятадын талаар өргөн мэдлэгтэй байгаад зогсохгүй монгол хэл, монгол бичгийн өргөн мэдлэг, монгол ёс заншлын талаар өргөн мэдлэгтэй байх.
5. Судалгааны арга зүйг сайтар эзэмших, хөтөлбөр төлөвлөгөөнд тусгаж өгөх.
6. Судалгааны арвин хэрэглэгдэхүүнтэй байхаас гадна хувийн судалгааны номын сантай байх, найруулан бичих чадвар сайтай байх. Иймээс судалгааны хэрэглэгдэхүүнийг олшруулах шаардлагатай.

7. Түүх, утга соёл, хэл бичиг, зан үйлийг сайн мэддэг байх.
8. Хятад болон хятад судлалын ерөнхий тоймыг сайтар мэддэг байх. Ингэснээр хятад судлалын судлагдаагүй хэсгийг олж харан судалгааны хоосон орон зайг нөхөж хийх боломж бүрдэнэ. Мөн түүнчлэн олон улсын хятад судлалын чиглэлээр өргөн ойлголттой байх
9. Хятад судлалын тойм судалгаа хийж үнэлгээ хийх
10. Хятад хүний сэтгэлгээг мэддэг байх
11. Судалгааны бусад гадаад хэл мэддэг байх. Дан ганц хятад хэлээр зогсохгүй судалгааны англи, орос, герман зэрэг хэлийг давхар эзэмшсэн байх.
12. Мөн бусад гадаад хэлнээс хэрэглээний түвшинд эзэмшсэн байх. Түүхийн явцад хятад хэлийг МЭ-II зууны үед ханзыг авч хэрэглэж байсан япон, солонгос зэрэг хэлийг хэрэглээний түвшинд эзэмшсэн байх.
13. Судалгааны хүрээнд номын бүртгэл, каталогитай байх.
14. Хятадын нутгийн аялгууны мэдлэгтэй байх. (汉语的八大方言, 有北方方言、吴方言、湘方言、赣方言、客家方言、闽南方言、闽东方言和粤方言。)
15. Хятадын олон үндэстний хэл, соёлын талаар гадарладаг байх. Түүгээр зогсохгүй нэг үндэстний талаар дагнасан судалгаа ч хийх боломжтой。(回族, 藏族, 维吾尔族 гэх мэт)
16. Хятад хэлний түвшнээ тодорхойлж, HSK, HSKK шалгалтын дээд шат (高级水平)-ны шалгалт өгч, гэрчилгээтэй болсон байх.

Ерөнхий дүгнэлт

Монгол Улсад хятад судлалыг уламжлалт түүх, соёл, гүн ухаан, шашин, хэл шинжлэл, үндэстний цөөнхийн судалгааны салбарт үргэлжлүүлэн хөгжүүлж байгаагаас гадна орчин үеийн хятадын гадаад, дотоод бодлого, нийгэм эдийн засгийн хөгжлийн судалгаа, хоёр орны харилцааны тулгамдсан асуудлуудад чиглүүлэн хөгжүүлж байна.

Гэсэн хэдий ч хятад улс эдийн засгийн хувьд хүчирхэгжин хөгжиж, олон улсын тавцанд түүний эзлэх байр суурь, нэр хүнд өсөн нэмэгдэж, гадаад харилцаа, ялангуяа эдийн засгийн гадаад харилцаагаа эрчимтэй хөгжүүлж байгаа өнөө үед Монгол дахь хятад судлалыг цаг үеийн хэрэгцээ хангасан прагматик хятад судлалд хөгжүүлэх шаардлага улам бүр тулгарч байна.

Ашигласан материал:

- Н.Алтантөгс ХХ зууны монголын түүх I, “Монгол-Хятадын социалист найрамдлын мандал буурлын түүх”, МУИС Пресс хэвлэлийн газар, 2019 он.
- 陈岗龙, 《改革开放三十年蒙古比较文学研究的回顾与展望》
- Л.Маналжав” Монголын нууц товчооны хэлний судалгаа”, 2017
- Л.Маналжав” Хэл шинжлэлийн өгүүллүүд ”, 2018
- “Монгол, хятадын харилцаа жарнаас жаранд” МУИС, ОУХС, УБ, 2010 он, “Admon” хэвлэлийн газар, 160х.
- МУИС, “Хятад судлалын салбар Нэгэн жаран”, УБ 2017 он, Удам соёл ХХК, 336 хуудас
- Г.Цогзолмаа нар “Боловсролын түүчээ” 65 жил (МУБИС 1951-2016) 378 хуудас, 2016 он, “Соёмбо принтинг” хэвлэлийн газарт.
- Г.Цогзолмаа “Нэр томьёо судлал”, УБ., 2013 он, “ Монгол хэлнээ орсон зарим хятад гаралтай үгийн үгийн санжих хийгээд нэр томьёожих үзэгдэл”, 55-75-р тал.
- Г.Цогзолмаа, 《蒙古国汉语教学现状》.
- 文英, 文化转向视野中的《清澈的塔米尔河》汉译
- ШУА, Олон улсын харилцааны хүрээлэн “Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: боломж, сорилт”, УБ, 2020 он, Бемби сан хэвлэлийн газар, 187х
- Д.Шүрхүү, Б.Энхчимэг нар “Монголын хятад судлал” аман түүх, 2016 он, Бэмби сан хэвлэх үйлдвэр, 327хуудас.
- 张艳华, 《面向海外本土汉语教师的国别化培训方略探析---以蒙古为例》